

ИНТЕРНЭТИЙН БӨӨНИЙ ҮЙЛЧЛЭГЧИЙН СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ны 2021 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын (цаашид “журам” гэх) 2.5¹ дахь хэсэгт зааснаар харилцаа холбооны үйлчлэгч буюу интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгч нь өөрийн сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлийг (цаашид “нөхцөл” гэх) боловсруулан Зохицуулах хороогоор хянуулан баталж өөрийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, цахим хуудсандаа байршуулах үүрэгтэй.

1.2 Энэхүү сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлийн зорилго нь интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгч интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд холбогдох үйл ажиллагааг нээлттэй болгох, интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчийн сүлжээнд холбогдох эрхийг баталгаажуулах, интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгчдийн техник технологийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх зэргээр энэ нөхцөлийн 1.1 дэх хэсэгт заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд оршино.

1.3 Интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгч нь интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий үйлчлэгчтэй сүлжээнд холбогдох гэрээ байгуулахдаа хууль, журам болон энэхүү нөхцөлд заасан хэм хэмжээг мөрдөнө.

ХОЁР. НЭР ТОМЬЁО

2.1 “Сүлжээнд холбогдох гэрээний нөхцөл” гэж “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын 2.5 дахь хэсэгт заасан мэдээллийг агуулсан баримт бичгийг ойлгоно.

2.2 “Харилцаа холбооны үйлчлэгч” гэж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16²-д заасан үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.

¹ Харилцаа холбооны үйлчлэгч нь өөрийн сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлийг (RAO) боловсруулан Зохицуулах хороогоор хянуулан баталж өөрийн веб хуудсанд байршуулах бөгөөд дараах мэдээллийг заавал тусгасан байна. Үүнд: 2.5.1. 2.5.1 Тухайн сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага
2.5.2. Зааглах цэгийн байршил,

2.5.3.Сүлжээнд холбогдох төлбөр тооцооны мэдээлэл,

2.5.4.Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл,

2.5.5.Гэрээний загвар

² 15. 16. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр:

15. 16.1. радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах,

15.16.2. харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх,

2.3 "Интернэтийн бөөний үйлчлэгч" гэж Харилцаа холбооны Зохицуулах хорооны 2020 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл, шаардлага"-ын 4.2³ дахь хэсэгт зааснаар мэдээлэл холбооны улс хоорондын сүлжээ байгуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийг ойлгоно.

2.4 "Интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгч" гэж Зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн ангилал"-ын 2.1 дэх хэсэгт заасан харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг мэдээлэл холбооны үйлчилгээ (интернэт) төрлөөр авсан иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.

ГУРАВ. СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ТЕХНОЛОГИЙН СТАНДАРТ, ГОРИМ, НӨХЦӨЛ ШААРДЛАГА

3.1 Интернэтийн бөөний үйлчлэгч харилцан холболт хийхдээ үйлчлүүлэгчээс ХХЗХ-ны тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын дагуу үйлчилгээний чанар, харилцан холболт хийх "Техник, тоног төхөөрөмж нь бусад үйлчлэгчийн сүлжээтэй харилцан холбогдох техникийн нөхцөлийг хангасан байх" гэсэн шаардлагыг хангасан байхыг шаардах ба үйлчилгээний аюулгүй байдал, хандлагаас сэргийлсэн төхөөрөмжтэй байх, хэрэглэгчийнхээ портыг хааж чаддаг байхыг шаардаж болно.

3.2 Энэхүү нөхцөлийн 3.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчийг сүлжээндээ холбохоос татгалзаж болно. Энэ тохиолдолд журмын 3.2 дахь хэсэгт заасан хугацаанд.

3.3 дахь хэсэгт заасан тайлбарыг албан бичгээр мэдэгдэнэ. 3.3 Интернэтийн бөөний үйлчлэгч нь энэхүү нөхцөлд тусгагдсан сулжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлагаас өөр нөхцөлийг интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдэд тавихыг хориглоно.

3.4 Зохицуулах хороо интернэтийн бөөний үйлчлэгч өөрийн сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлагыг тогтооход газар дээр нь хэмжилт, шалгалт хийж болно.

ДӨРӨВ. ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

4.1 Интернэтийн бөөний үйлчлэгч нь зааглах цэгийн байршлыг журмын нэгдүгээр хавсралтын 3.2 дахь хэсэгт зааснаар аль нэг үйлчилгээ эрхлэгчийн сүлжээний эсхүл дамжуулах төхөөрөмжөөр тогтооно.

4.2 Зааглах цэгийн байршлыг энэхүү нөхцөлийн 4.1 дэх хэсэгт зааснаас өөр байрлалд тогтоохоор бол журмын 5.3 дахь хэсэгт зааснаар интернэтийн үйлчилгээ

15. 16.3. контентийн үйлчилгээ эрхлэх;

15. 16.4. тоон гарын үсгийн гэрчилгээ олгох

³ 4.2 Энэхүү нөхцөл, шаардлагын 2.3.1-д заасан мэдээлэл холбооны улс хоорондын сүлжээ байгуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь интернэтийн бөөний урсгал нийлүүлэх үйлчилгээ эрхэлж болох бөгөөд уг үйлчилгээг зөвхөн интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлнэ.

эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгч уг хүсэлтийг гаргасан тохиолдолд интернэтийн бөөний үйлчлэгч нь хүсэлтийн дагуу техникийн нөхцөлийн боломж

байгаа эсэхийг тодорхойлж, дүгнэлтийг зохицуулах хороонд албан бичгээр ирүүлж, шийдвэрлүүлнэ. Харин интернэтийн бөөний үйлчлэгч нь зааглах цэгийн байршлыг энэхүү нөхцөлийн 4.1 дэх хэсэгт зааснаас өөр байрлалд тогтоох хүсэлттэй бол Зохицуулах хороонд үндэслэл, техникийн нөхцөлийн боломжийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлж, тухай бүр шийдвэрлүүлнэ.

4.3 Зааглах цэгийн байршлыг энэхүү нөхцөлийн долдугаар зүйлийн гэрээний загвар хэсэгт энэхүү нөхцөлийн 4.1 дэх хэсгийн дагуу интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчтэй харилцан тохиролцсоноор нарийвчлан, тодорхой оруулна.

4.4 Интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгч нь харилцаа холбооны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1⁴ дэх хэсэгт заасны дагуу интернэтийн бөөний үйлчлэгч сүлжээнд холболт хийх цэг хүртэл шаардагдах хөрөнгө оруулалтыг хариуцна.

4.5 Талууд үйлчилгээний чанарын шаардлагыг хангах үүднээс тус тусын хариуцаж буй зааглах цэг хүртэлх сүлжээ, дэд бүтцийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд энэхүү нөхцөлийн долдугаар зүйлд заасан гэрээний загварт дангаар эсхүл харилцан тусгай нөхцөл тогтоож болно.

ТАВ. СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ТӨЛБӨР ТООЦООНЫ МЭДЭЭЛЭЛ

5.1 Интернэтийн бөөний үйлчлэгчийн сүлжээнд холбогдох анхны холболтын төлбөрийн мэдээллийг цахим хуудасны "Үнэ тариф" хэсгээс авах.

5.2 Интернэтийн бөөний үйлчлэгч нь тухайн зах зээлд давамгайл байдалтай аж ахуйн нэгжээр тогтоогдсон бол "Дотоодод борлуулах интернэтийн урсгалын бөөний үйлчилгээний доод үнэ"- ээс бууруулахгүй.

5.3 Интернэтийн бөөний үйлчлэгч нь үйлчилгээний үнэ тарифаа өөрийн цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээллэнэ.

5.4 Ашиглалт үйлчилгээний болон сүлжээнд холбогдох төлбөрийг энэхүү нөхцөлийн 7.1 дэх хэсэгт заасан гэрээнд тус тусдаа ялган оруулж, зохицуулна.

ЗУРГАА, ГЭРЭЭ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НАРИЙВЧИЛСАН МЭДЭЭЛЭЛ

6.1 Интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгч интернэтийн бөөний үйлчилгээ авах, сүлжээнд холбогдох хүсэлтээ журмын 3.1⁵ дэх хэсэгт заасан хэлбэрээр гаргах бөгөөд интернэтийн бөөний үйлчлэгч нь уг хэлбэрээс бусад хэлбэрээр гаргасан аливаа хүсэлтийг шийдвэрлэхгүй.

⁴ 22.1. Тусгай хэрэглээний холбооны сүлжээ эзэмшигч, дотоодын хэрэглээний сүлжээ бүхий болон шинээр сүлжээ байгуулах этгээд бусдын өмчлөлийн сүлжээнд холболт хийхдээ сүлжээ хоорондын зааглах цэгт тавигдах нэмэгдэл шугам, тоног төхөөрөмжийг хариуцна.

⁵ Харилцаа холбооны үйлчилгээгээр үйлчлэгч нь сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлтийг харилцаа холбооны үйлчлэгчид бичгээр гаргана.

6.2 Интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгч интернэтийн бөөний үйлчилгээ авах, сүлжээнд холбогдох хүсэлтдээ дараах мэдээллийг заавал тусгана. Үүнд:

6.2.1 Сүлжээнд холбогдох зааглах цэгийн байршил:

6.2.2 Холболт хийх гэж буй төхөөрөмжийн талаар мэдээлэл;

6.2.3 Авахаар төлөвлөж буй интернэт урсгалын хэмжээ:

6.2.4 Энэхүү нөхцөлийн гуравдугаарт зүйлд тусгасан гэрээний нөхцөлийг хангах талаар бусад мэдээлэл зэрэг болно.

6.3 Интернэтийн бөөний үйлчлэгч нь техникийн нөхцөл олгох боломжийг судлах зорилгоор энэхүү нөхцөлийн 6.2 дахь хэсэгт зааснаас бусад байгууллагын Нэмэлт мэдээлэл шаардаж болно.

6.4 Интернэтийн бөөний үйлчлэгч нь энэхүү нөхцөлийн 6.1 дэх хэсэгт заасан хэлбэрээс өөр хэлбэрээр ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй талаар мэдэгдлийг бичгээр мэдэгдэнэ.

6.5 Интернэтийн бөөний үйлчлэгч нь Зохицуулах хорооны 2020 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл, шаардлага"-ын 4.2⁶ дахь хэсэгт заасны дагуу зөвхөн интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчийн сүлжээнд холбогдох хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ.

6.6 Интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдээс бусад этгээд сүлжээнд холбогдох хүсэлт ирүүлсэн тохиолдолд татгалзах эрхтэй.

6.7 Интернэтийн бөөний үйлчлэгч нь интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчдийн ирүүлсэн хүсэлтийг хүлээн авсан өдрөөр шүүж, түрүүлж ирснийг нь эхэнд шийдвэрлэх зарчим баримтлана.

6.8 Интернэтийн бөөний үйлчлэгч нь энэхүү нөхцөлийн 6.1 дэх хэсэгт заасан хүсэлтийг хүлээн авч энэхүү нөхцөлийн гуравдугаар зүйл сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлагад нийцэж байгаа эсэхийг судалж, журмын 3.2⁷ дахь хэсэгт заасан хэлбэр, хугацаанд хариу мэдэгдэнэ. Энэ мэдэгдлийг техникийн нөхцөл гэж ойлгоно.

6.9 Интернэтийн бөөний үйлчлэгч нь интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчид техникийн нөхцөл гаргах боломжгүй болсон

⁶ энэхүү баримт бичгийн 3.3.1-т заасан мэдээлэл холбооны улс хоорондын сүлжээ байгуулах А ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь интернэтийн бөөний үйлчилгээ эрхэлж болох бөгөөд уг үйлчилгээг зөвхөн интернэтийн үйлчилгээ эрхлэх Бангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлнэ.

⁷ Харилцаа холбооны үйлчлэгч нь уг хүсэлтийг хүлээн авч өөрийн сүлжээний техникийн боломж, гэрээний нөхцөлийг хангаж буй эсэхийг нягталж, өөрийн сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх боломжтой эсэх талаар судалж, ажлын 10 хоногийн дотор хариуг хүсэлт гаргасан талд бичгээр мэдэгдэнэ

тохиолдолд журмын 3.3⁸ дахь хэсэгт зсны дагуу хариу хүргүүлэх бөгөөд уг хариу тайлбартаа техникийн нөхцөл олгох боломжгүй үндэслэлийг тодорхой дурдана.

6.10 Интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчийн тусгай зөвшөөрөл нь хуульд заасан үндэслэлээр хүчингүй болсон тохиолдолд интернэтийн бөөний үйлчлэгчээс олгогдсон техникийн нөхцөл хүчингүй болно. Мөн тус Интернетийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгч нь интернетийн бөөний үйлчлэгчтэй үүссэн төлбөр тооцоог бүрэн барагдуулж дуусгана.

6.11 Интернэтийн бөөний үйлчлэгч нь журмын 4.3⁹ хэсэгт заасан бүртгэлийн гэрчилгээ авсан этгээдийг өөрийн сүлжээндээ холбохгүй.

6.12 Зохицуулах хорооны албан тушаалтан сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлийг хянахдаа гуравдугаар зүйлд заасан сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлагыг баталгаажуулах зорилгоор тоног төхөөрөмжийг газар дээр нь очиж, хяналт хийж болно.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

7.1 Интернэтийн бөөний үйлчлэгч нь Харилцаа холбооны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1¹⁰ дэх хэсэгт зааснаар интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчийг өөрийн сүлжээндээ холбохдоо гэрээ байгуулна.

7.2 Энэхүү нөхцөлийн 7.1 дэх хэсэгт заасан гэрээг сүлжээнд холбогдох болон сүлжээний ашиглалт, үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулахаар байгуулна. Сүлжээний ашиглалт, үйлчилгээг зохицуулахаар тусдаа гэрээ байгуулахыг хориглоно.

7.3 Сүлжээнд холбогдох гэрээний төслийг холбогдох хууль тогтоомж, Зохицуулах хорооноос баталсан шийдвэр, зохицуулалт, нөхцөл шаардлага, журамтай нийцүүлэн боловсруулж, Хавсралт 1-ээр Интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгч нартай байгуулдаг гэрээний ерөнхий загварыг хавсаргав.

7.4 Интернэтийн бөөний үйлчлэгч нь сүлжээнд холбогдох гэрээний төслийг боловсруулахдаа энэхүү нөхцөлийн гуравдугаар зүйлд заасан сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлагыг салшгүй хэсэг болгоно.

7.5 Энэхүү нөхцөлийн 7.3 дахь хэсэгт заасан гэрээний салшгүй хэсэг сүлжээнд холболт хийж буй интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчийн хүсэлтээр хууль болон зохицуулах хорооноос баталсан журам

⁸ Харилцаа холбооны үйлчлэгч нь техникийн нөхцөл гаргах боломжгүй бол хүсэлт гаргагч талд тухайн нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болох хугацааг тодорхой дурдсан холбогдох тайлбарыг хүргүүлэх ба хувийг зохицуулах хороонд заавал ирүүлнэ.

⁹ Харилцаа холбооны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт заасны дагуу бүртгэл хийлгэсэн иргэн, хуулийн этгээд нь бүртгэлийн гэрчилгээ авснаас хойш 3 сарын дотор холболтоо хийж эхлээгүй бол техникийн нөхцөл хүчингүй болно.

¹⁰ Үйлчлэгч, хэрэглэгчийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг Иргэний хуульд заасны дагуу гэрээгээр зохицуулна.

нөхцөл шаардлага, шийдвэрээр хязгаарласан асуудлаас бусад асуудлаар харилцан тохиролцон өөрчлөлт оруулах боломжтой байна. Бусад тохиолдолд интернэтийн бөөний үйлчлэгч нь энэхүү нөхцөлийн гуравдугаар зүйлд зааснаас өөрөөр гэрээнд оруулахыг хориглоно.

7.6 Интернэтийн бөөний үйлчлэгч нь интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчийн техникийн нөхцөл энэхүү нөхцөлийн 6.10 дахь хэсэгт зааснаар хүчингүй болсон тохиолдолд сүлжээний холболтыг салгах арга хэмжээ авч, зохицуулах хороонд албан бичгээр мэдэгдэх бөгөөд сүлжээнд холбогдох гэрээндээ уг нөхцөлийг хэрэгжүүлэх заалтыг заавал тусгана.

7.7 Интернэтийн бөөний үйлчлэгч болон интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгч нь сүлжээний ашиглалт, үйлчилгээг журмын 7.2 дахь хэсэгт зааснаас өөрөөр хариуцах тохиолдолд гэрээндээ энэ талаар тодорхой тусгана.

7.8 Журмын 7.3¹² дахь хэсэгт заасан сүлжээнд холбогдох аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт, гэмтэл саатлын үед ажиллах горим, хугацааг талууд тохиролцон гэрээндээ тусгана.

НАЙМ. ГОМДОЛ ГАРГАХ

8.1 Энэхүү нөхцөлтэй холбоотой аливаа маргаантай асуудлаар журмын 10.1¹³ дэх хэсэгт заасны дагуу зохицуулах хороонд хандаж шийдвэрлүүлэх боломжтой.

-oOo-

¹¹ Талууд сүлжээнд холбогдох зааглах цэгээс 2 тийш тус тусын сүлжээний ашиглалт, үйлчилгээг хариуцна.

¹² Сүлжээнд холбогдох аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт, гэмтэл саатлын үед ажиллах горим, хугацааг талууд урьдчилж харилцан тохиролцон тогтоох ба үйл ажиллагаандаа мөрдөн ажиллана.

¹³ Сүлжээнд холбогдох гэрээний нөхцөл, зааглах цэг, төлбөр, журам болон гэрээг зөрчсөн, өрсөлдөөний эсрэг үйлдэл гаргасан зэрэг маргаантай асуудлыг маргалдагч талууд шат шатандаа шийдвэрлэхийг зорих бөгөөд шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Харилцаа холбооны тухай хуулийн 31.2 заалтын дагуу Зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэнэ

ИНТЕРНЭТИЙН УРСГАЛААР ХАНГАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

.....оны ... сарын ..

No

Улаанбаатар хот

Нэг талаас МТ Нэтворкс ххк (цаашид Нийлүүлэгч гэх)-ийг төлөөлж Гүйцэтгэх захиралнөгөө талаас ХХК (цаашид Захиалагч гэх)-ийг төлөөлж гүйцэтгэх захирал (цаашид хамтад нь “Талууд”, дангаар нь “Тал” гэх) нар холбогдох хуулийг удирдлага болгон дараах нөхцөлийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээгээр нийлүүлэгч нь өөрийн шилэн кабелийн сүлжээг ашиглан Захиалагчийн захиалгын дагуу интернэтийн урсгалаар хангах үйлчилгээ (цаашид Үйлчилгээ гэх)-г 24 цагийн турш тасралтгүй үзүүлэх харилцааг зохицуулна.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Гэрээний хүчинтэй хугацаа оны-р сарын-с оны-р сарын ...-ийг дуустал жилийн турш үйлчлэх ба энэ хугацааг хуульд зааснаас бусад үндэслэлээр тасалдуулж үл болно.

2.2 Гэрээний хугацаа дуусахад талууд гэрээг дуусгавар болгох талаар санал тавиагүй бол гэрээ нь ижил нөхцөлөөр 1 жилээр сунгагдсанд тооцно.

2.3 Энэ гэрээнд тусгайлан зааснаас бусад хугацааг хуанлийн хоногоор тооцно.

Гурав. Нийлүүлэгчийн эрх, үүрэг

3.1 Захиалгын хуудсанд заасан урсгалын үйлчилгээг найдвартай, чанартай, шуурхай үзүүлнэ.

3.2 Гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Захиалагч талтай харилцан тохиролцсоны үндсэн дээр өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тухай саналаа Захиалагчид 1 сараас доошгүй хугацааны өмнө албан бичгээр мэдэгдэнэ.

3.3 Төлөвлөгөөт болон техникийн үзлэг үйлчилгээг жилд 4-өөс доошгүй удаа 1 цагаас ихгүй хугацаанд хийнэ. Техникийн үзлэг үйлчилгээ хийх тухай Захиалагчид ажлын 3 өдрийн өмнө урьдчилан мэдэгдэж Захиалагчийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх илүү тохиромжтой үеийг харилцан тохиролцож хийнэ. Энэ хугацаа нь Үйлчилгээ тасалдсанд тооцогдохгүй.

3.4 Захиалагчийн гаргасан хүсэлтийн дагуу шаардлагатай техникийн хэмжилт, туршилтыг хийж өгнө.

3.5 Өөрийн сүлжээнд гэнэтийн осол, гэмтэл саатал гарсан үед аль болох хурдан засварлах, нөөц сүлжээнд шилжүүлэх зэрэг арга хэмжээг авна.

3.6 Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас гарсан гэмтэл, түүний буруу (сүлжээнд зохицохгүй тоног тохөөрөмж холбох г.м) шийдвэрээс гарч болох сөрөг үр дагаврын хариуцлагыг Нийлүүлэгч хүлээхгүй ба энэхүү асуудлыг шийдвэрлэхэд гарах үйлчилгээний зардлыг гэмтлийн шалтгааныг тодруулсан актыг үндэслэн, Захиалагч төлж барагдуулна.

3.7 Үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөхийг шаардах, гэрээний 6.4-т заасны дагуу төлбөрөө төлөөгүй бол нийлүүлэгч үйлчилгээг зогсоох, дангаар гэрээг цуцлах эрхтэй.

3.8 Нийлүүлэгч нь Захиалагчийн хэрэглэгчид үзүүлж буй үйлчилгээнд хариуцлага хүлээхгүй.

3.9 Захиалагч гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой буюу удаа дараа зөрчсөн, төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд үйлчилгээг зогсоох эсвэл энэ гэрээний 7-р зүйлд заасны дагуу гэрээг нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.

3.10 Хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

4.1 Захиалагч нь өөрийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, түүний тохируулга, сайжруулалт, өөрчлөлт, өргөтгөл, засвар үйлчилгээ, шилжүүлэлт, суурилуулалтын зардлыг бүрэн хариуцна.

4.2 Захиалагч нь өөрийн үйлчилгээг явуулахад шаардлагатай интернэтийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч байх ба олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний талаар үүсэх асуудлыг харилцаа холбооны зохицуулах хорооны өмнө дангаар хариуцна.

4.3 Захиалагч нь харилцаа холбооны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журмыг дагаж мөрдөнө.

4.4 Үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд, интернэтийн нийтлэг стандартын дагуу хуулийн хүрээнд ашиглана. Буруу хэрэглээнээс үүдэн гарах хариуцлагыг Захиалагч бүрэн хүлээнэ.

4.5 Нийлүүлэгчийн сүлжээний аль ч хэсэгт түүний зөвшөөрөлгүйгээр аливаа тоног төхөөрөмж суурилуулж, нэмэлт өөрчлөлт, холболт хийхгүй байх үүргийг хүлээнэ.

4.6 Захиалагч нь нийлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр үйлчилгээг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

4.7 Захиалагч нь гэрээний 2.1-т заасан хугацаанд үйлчилгээг тасралтгүй ашиглах үүрэгтэй.

4.8 Захиалагчийн буруутай үйл ажиллагааны улмаас Үйлчилгээ зогссон тохиолдолд учирсан хохирол, түүнээс гарах үр дагаврыг бүрэн хариуцна.

4.9 Үйлчилгээтэй холбоотой ямар нэг гэмтэл саатал гарсан тохиолдолд 981040000 утсанд яаралтай мэдэгдэнэ.

4.10 Захиалагч нь үйлчилгээний талаар санал, гомдлоо илэрхийлэх бөгөөд хариуг авах эрхтэй.

4.11 Хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Тав. Техникийн холболт

5.1 Талуудын техникийн холболтын цэг нь байна.

5.2 Талууд холболтын цэг хүртэлх тус тусын техникийн холболт түүний ашиглалт үйлчилгээг бүрэн хариуцна.

Зургаа. Төлбөр тооцоо хийх журам

6.1 Нийлүүлэгч нь төлбөрийг тухайн тайлант сарын 10-ны дотор урьдчилан нэхэмжлэх ба нэхэмжлэхийг гэрээний Хавсралт №1-д заагдсан и-мэйл, факсаар илгээнэ. Захиалагч нь өөрийн талын төлбөр тооцоо хариуцсан албан тушаалтны нэр, и-мэйл хаяг, утас, факсын дугаар өөрчлөгдсөн тохиолдолд нийлүүлэгч талд албан бичгээр мэдэгдэнэ.

6.2 Нийлүүлэгч нь Захиалагчаас төлбөр хүлээн авсны дараа НӨАТ-ын хуулийн 17.3.4 заалтын дагуу холбогдох мэдээллийг 7 хоногт багтаан татварын нэгдсэн системд илгээх ба НӨАТ-ын хуулийн 4.1.14 заалтын дагуу шаардлага хангасан төлбөрийн баримтыг Захиалагчийн хавсралт 1-т заасан хаяг руу илгээнэ.

6.3 Үйлчилгээ болон төлбөр тооцоо эхлэх хугацааг гэрээ байгуулагдаж, холболт хийгдэж холболтын акт үйлдэгдэж үйлчилгээ авч эхэлснээр тооцон нэхэмжилнэ.

6.4 Захиалагч нь сарын үйлчилгээний төлбөрийг нийлүүлэгчийн нэхэмжлэхийн дагуу тухайн тайлант сарын 20-ны өдрийн дотор төлнө.

6.5 Төлбөрийг тооцооны сараар авах ба энэ хугацаа нь хуанлийн сартай тэнцүү байна.

6.6 Захиалагчийн тухайн сарын ашигласан интернэт урсгалын хэмжээ нь гэрээний Хавсралт № 2-т тусгагдснаас илүү гарсан тохиолдолд тус илүү гарсан интернэтийн урсгалын төлбөрийг Нийлүүлэгч талын 5 минутын алхамтай Сacti программын 95 хувиар үндэслэн тогтоож, Талууд хооронд баталгаажуулсан актын дагуу тус төлбөрийг ирэх сарын үндсэн төлбөр дээр нэмж нэхэмжилнэ.

6.7 Гэмтлийн актанд тухайн саатал гарсан шалтгаан, авсан арга хэмжээ, үргэлжилсэн нийт хугацаа болон урсгалын төлбөрөөс хасч тооцох хугацаа зэргийг тодорхой зааж өгнө.

6.8 Захиалагч нь “Үнэ тариф”-д заасны дагуу нэхэмжилсэн төлбөрийг Хавсралт №1-д заасан Нийлүүлэгчийн валютын болон төгрөгийн дансанд шилжүүлнэ. Төлбөрийн даалгаврыг факсаар явуулах буюу и-мэйлээр илгээж болно.

6.9 Захиалагч нь сарын үйлчилгээний төлбөрийг Нийлүүлэгч-ийн нэхэмжлэхийн дагуу тухайн сарын 20-ны өдрийн дотор төлнө. Нэхэмжилсэн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч ажлын 3 хоногийн дотор сануулга өгөх ба үүний дараа ажлын 5 хоногийн дотор төлбөр хийгдээгүй бол үйлчилгээг зогсоох эрхтэй.

6.10 Тухайн сард гарсан гэмтлийн нийт хугацааг техникийн дүгнэлтийн үндсэн дээр акт үйлдэн тогтоож, үйлчилгээ тасалдсан хугацааны төлбөрийг ирэх сарын хураамжаас хасаж тооцно.

Долоо. Гэрээг өөрчлөх, цуцлах, сунгах

7.1. Энэхүү гэрээний нөхцөлүүд 2.1-д заасан хугацаанд ямарваа нэгэн өөрчлөлтгүйгээр даган мөрдөгдөнө.

7.2 Энэхүү гэрээнд гагцхүү Талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр хийсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулах бөгөөд эх хувьд баллаж засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно.

7.3 Хоёр талын аль нэг нь энэ гэрээг хугацаанаас өмнө эсхүл гэрээнд өөрчлөлт оруулахыг хүсвэл энэ тухайгаа 1 сараас доошгүй хугацааны өмнө нөгөө талд албан бичгээр мэдэгдэнэ.

7.4 Захиалагчийн талаас өөрийн өгсөн захиалгын дагуу үйлчилгээг хүлээж авахаас өмнө захиалгыг дуусгавар болгох, эсхүл гэрээг, эсхүл захиалгыг

хугацаанаас өмнө цуцлах хүсэлт гаргах тохиолдолд цуцалсан өдрөөс хүчинтэй хугацаа дуусах хүртэлх хугацааны үйлчилгээний төлбөрийг 100% төлнө.

7.5 Гэрээ дуусгавар болсноор эсвэл гэрээг цуцлагдсанаар үйлчилгээг зогсоосон тохиолдолд талуудаас томилогдсон албан тушаалтнууд энэ тухай акт үйлдэх бөгөөд акт үйлдсэн өдрийг үндэслэн төлбөр тооцоог зогсооно.

7.6 Дараах тохиолдолд Талууд гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

7.6.1 Талууд албан бичгээр харилцан тохиролцсоноор;

7.6.2 Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачилгаар;

7.7 Захиалагч үйлчилгээг хүлээн авснаас хойш захиалгыг дуусгавар болгон цуцлах хүсэлт гаргах тохиолдолд гэрээг цуцлах тухай хүсэлтээ гэрээ дуусах хугацаанаас нэг сарын өмнө албан бичгээр ирүүлнэ.

7.8 Гэрээ цуцлахаас өмнө Талуудын санхүү хариуцсан ажилчид тооцоо нийлж, өр төлбөргүйг баталгаажуулсны үндсэн дээр гэрээ цуцлагдсанд тооцно.

7.9 Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд санаачлагч Тал ажлын 10 хоногийн өмнө бичгээр мэдэгдэж өөрчлөлт оруулна. Энэхүү өөрчлөлт нь Талууд гарын үсэг зурснаар баталгаажна.

Найм. Талуудын хүлээх хариуцлага

8.1 Үйлчилгээ үзүүлж байх хугацаанд Нийлүүлэгчийн сүлжээнд гэмтэл саатал гарсан тохиолдолд энэ талаар техникийн дүгнэлтийн үндсэн дээр Талууд акт үйлдэн, тухайн саатлын гарсан шалтгаан, авсан арга хэмжээ, үргэлжилсэн нийт хугацаа зэргийг тодорхой зааж өгнө.

8.2 Нийлүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан гэмтэл саатлыг талууд акт үйлдэж баталгаажуулах бөгөөд тасалдсан хугацааны төлбөрийг тооцохдоо тухайн сарын хуанлийн хоногийг цагт шилжүүлэн үүнээс гэмтэл саатлын тасалдсан хугацаа /цаг/-г хасч ногдох төлбөрийг тодорхойлно. Энэхүү хасч тооцох төлбөрийг захиалагчийн дараа сард төлөх төлбөрөөс хасч тооцож нэхэмжилнэ.

8.3 Гуравдагч этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас үйлчилгээний хэвийн үйл ажиллагаа алдагдсан тохиолдолд нийлүүлэгч хариуцлага хүлээхгүй бөгөөд энэ тохиолдолд гэрээний 8.2-т заасны дагуу гэмтэл саатлын үеийн төлбөрийн хасалт /хөнгөлөлт/-ыг Захиалагчид олгохгүй.

8.4 Захиалагч нь гэрээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд (сар бүрийн 10-ны дотор) төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутам гэрээний гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг Нийлүүлэгчид төлнө.

8.5 Талууд харилцан бие биедээ гаргасан гомдлын шаардлага, санал хүсэлтийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор хянан үзэж хариуг өгөх үүрэгтэй. Хэрэв дурдсан хугацаанд хариу өгөөгүй бол гомдлын шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

Ес. Нууц хадгалах

9.1 Талууд энэхүү гэрээг байгуулсан тухай болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бус замаар олж мэдсэн байгууллага, хувийн нууцад аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгэн, аман болон аливаа бусад хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

9.2 Энэхүү гэрээний 9.1-д заасан нөхцөлийг аль нэг тал зөрчсөн тохиолдолд үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа хохирлыг бүрэн барагдуулна.

Арав. Давагдашгүй хүчин зүйл

10.1 Холбогдох хууль тогтоомжид заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

10.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

10.3 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, эрчим хүчний тасалдал 72 цаг ба түүнээс их хугацаагаар тасралтгүй үргэлжилсэн, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, тэр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

10.4 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.

Арван нэг. Маргаан шийдвэрлэх

11.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцох замаар шийдвэрлэнэ.

11.2 Санал зөрөлдөөн, маргааныг зөвшилцөөнөөр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Талуудыг харьяалах шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арван хоёр. Бусад зүйл

12.1 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талынхаа албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчилсэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй.

12.2 Энэ гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

12.3 Талуудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид, өмчлөгчид нь өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ нь үйлчлэх хугацааны туршдаа хүчин төгөлдөр байна.

12.4 Энэхүү гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

12.5 Энэхүү гэрээ нь Талууд харилцан гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

Талуудын албан ёсны хаяг, бусад өгөгдлүүд:

Нийлүүлэгч: МТ Нэтворкс ХХК
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо
НҮБ-ын гудамж- Утас: 98104000
Улсын бүртгэлийн дугаар: 901 1389141
Регистрийн дугаар: 5680026 Утас:

Захиалагч: ХХК :
Хаяг:
Утас:
Улсын бүртгэлийн дугаар: 9011663011
Регистрийн дугаар: 6157793

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.

“НИЙЛҮҮЛЭГЧ”-ийг төлөөлөн:

.....

Гүйцэтгэх захирал

.....

Менежер

“ЗАХИАЛАГЧ”-ийг төлөөлөн:

.....

Гүйцэтгэх захирал

.....

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ.

МТ Нэтворкс ХХК болон-ийн хооронд байгуулсан

.....тоот гэрээний ХАВСРАЛТ-1

1.1 НИЙЛҮҮЛЭГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ:

№	Харилцах асуудал	Захиалагчийн харилцах ажилтны мэдээлэл	
1	Гэрээ хэлцэл, төлбөр тооцоо, үйлчилгээ	Нэр Цахим шуудан Утас Гар утас
3	Техникийн асуудлаар	Нэр Цахим шуудан Утас Гар утас
4	Санхүү, төлбөр тооцоо	Нэр Цахим шуудан Утас Гар утас
5	Үйлчилгээ тасалдсан тохиолдолд	Утас	98104000,

1.2 ЗАХИАЛАГЧ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ:

№	Харилцах асуудал	Захиалагчийн харилцах ажилтны мэдээлэл	
1	Гэрээ хэлцэл, төлбөр тооцоо, үйлчилгээ	Нэр Цахим шуудан Утас Гар утас

3	Техникийн системд хийх үйлчилгээ, өөрчлөлт	Нэр Цахим шуудан Утас Гар утас
4	Санхүү, төлбөр тооцоо	Нэр Цахим шуудан Утас Гар утас

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ.

МТ Нэтворкс ХХК болон-ийн хооронд байгуулсан
..... тоот гэрээний ХАВСРАЛТ-2

ЗАХИАЛГЫН ХУУДАС №01

1. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХИАЛГА, ҮНЭ ТАРИФ

№	Үйлчилгээ авч буй чиглэл	Хурд (Мбит/с)	Нэгжийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /НӨАТ-тай/ /төгрөг/
1	Интернэтийн үйлчилгээ			

2. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ:

Захиалгын төрөл	А.Шинэ	Б. Өөрчилсөн.	Б.Сунгах	В.Цуцлах
Захиалгын хугацаа:	А.1 жил	Б.2 жил	В.3 жил	Г.4 жил
Үйлчилгээ болон төлбөр тооцоо эхлэх хугацаа оны .. сарын ... (Холболт үйлдсэн актаар)			

3. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ:

Сүлжээний Ай Пи (IP) блок хаяг:	
AS №	
Холболтын хурд (Mbps)	
Интерфейс	
Порт	

4.БУСАД.

4.1 Интернэтийн урсгалыг шинээр нэмж захиалах тухай бүр Талууд Захиалгын хуудсыг шинэчилнэ.

4.2 Захиалгын хүчинтэй хугацаанд авч буй интернэтийн урсгалын хэмжээг нэмэгдүүлсэн тохиолдолд үнэ тарифт харилцан тохиролцон өөрчлөлт оруулж болно.

4.3 Энэ захиалгын хуудас нь тоот гэрээний салшгүй хэсэг болно.

4.4 Энэхүү захиалгын хуудас нь Талууд харилцан гарын үсэг зурж, тэмдэг дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

ЗАХИАЛГЫГ БАТАЛГААЖУУЛСАН:

“НИЙЛҮҮЛЭГЧ”-ийг төлөөлөн:

.....

Гүйцэтгэх захирал

.....

.....

Менежер

“ЗАХИАЛАГЧ”-ийг төлөөлөн:

.....

Гүйцэтгэх захирал

.....

Энэхүү гэрээ болон МТ Нэтворкс ХХК-тай хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл хийг хүсвэл дараах хаягаар хандана уу. info@mtnetworks.mn